

## **ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, БҮРТГЭХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэ журмаар нийтэд нээлттэй санал болгон гаргах, эсхүл хаалттай хүрээнд санал болгон гаргаж, худалдах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, нээлттэй санал болгон гаргаж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах, хяналт тавих, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтийг тогтоох, Хорооны эрх, үүрэг болон тогтоосон хугацааны тухай бүр ирүүлэх мэдээллийн ил тод байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хороонд бүртгүүлээгүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчлах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл дээр нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр арилжихгүй.
- 1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээд нь нээлттэй хүрээнд санал болгон гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны талаар хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай эрсдэл өгөөжийн талаар хөрөнгө оруулагчид мэдээллийг өгч, харилцагчдыг таних ажиллагааг мэргэжлийн хөрөнгө оруулагч нар хэрэгжүүлнэ.
- 1.4. Тусгай зориулалтын компани дампуурах, төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд анхны үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгөөс хохирол барагдуулах, эсхүл анхны үүрэг гүйцэтгэгчийн зээлдэгч тусгай зориулалтын компаниас хохирол барагдуулах нэхэмжлэл гаргах эрхгүй бөгөөд үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдын хөрөнгө тусдаа байх зарчмыг бүх оролцогч мөрдөж, тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан тэнцэлд үнэт цаас гаргагчийн хөрөнгө шилжин бүртгэгдэж бодит арилжаа хийгдсэнээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өмчлөх эрх үүссэнд тооцно.
- 1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээр хөрөнгө оруулагчийн тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулан авах эрх баталгаажиж, транчийн төрлөөс хамааран төлбөрөө гаргуулах эрх нээгдэнэ.
- 1.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг шууд, эсхүл үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон биржийн бус зах зээлээр дамжуулан худалдах аль ч тохиолдолд Хороонд уг үнэт цаасыг бүртгүүлнэ.

**ХОЁР. Баталгаат үнэт цаасыг бүртгэх, түүний  
танилцуулга, тавигдах шаардлага**

- 2.1 Тусгай зориулалтын компани /цаашид “ТЗК” гэх/ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрөл авснаас хойш гурван сарын дотор өөрийн гаргах баталгаат үнэт цаасыг Хороонд бүртгүүлнэ.
- 2.2 ТЗК нь Хороонд баталгаат үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт гаргахдаа хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Хороонд бүртгэлтэй аудитын компанийг томилсон байна.
- 2.3 Хороонд баталгаат үнэт цаасаа бүртгүүлэхээр ирүүлсэн материал, баталгаат үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дарга, гишүүд гарын үсэг зурсан байх бөгөөд түүнд тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг ТЗК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүн бүрэн хариуцна.
- 2.4 Баталгаат үнэт цаасанд санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгож болох бөгөөд ТЗК-ийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий этгээдэд гаргаж өгсөн бичиг баримт нь Хороо, хөрөнгө оруулагчдад өгсөн мэдээлэлтэй адил байна.
- 2.5 Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий этгээд нь энэ журмын 2.6-д заасан дүгнэлтээс үүсэх хариуцлагыг бүрэн хариуцаж, үнэт цаас гаргагчтай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана.
- 2.6 ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.2-т зааснаас гадна баталгаат үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөлтэй хамт дараах баримт бичгүүдийг Хороонд цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлнэ:
  - 2.6.1 ТЗК-ийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд болон хараат бус гишүүдийн талаарх мэдээлэл, тэдгээрийн боловсрол, мэргэжил, одоо болон өмнөх ажил эрхэлсэн байдал, ажил мэргэжлийг илтгэх анкет, тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлоход шаардагдах баримт бичиг;
  - 2.6.2 үүсгэн байгуулагчдын саналын эрхтэй нийт энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл болон уг этгээдийн хувьцааг нь эзэмшдэг бусад хуулийн этгээдийн нэр, эзэмшдэг хувьцааны тоо ширхэг;
  - 2.6.3 үүсгэн байгуулагч нь банк бол Монголбанкнаас, банк бус санхүүгийн байгууллага бол Санхүүгийн зохицуулах хорооноос, орон сууцны санхүүжилтийн компани эсхүл бусад этгээд бол холбогдох этгээдээс тэдгээрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийг хангаж ажиллаж байгаа эсэх талаарх дүгнэлтийг шаардлагатай тохиолдолд Хороо гаргуулан авна;
  - 2.6.4 ТЗК-ийн дүрэм, шинэчилсэн дүрмийн төсөл, эхлэлтийн баланс;
  - 2.6.5 ТЗК-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмууд;
  - 2.6.6 үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хооронд сонирхлын үүсэхгүй талаарх баталгаа;
  - 2.6.7 хөрөнгө итгэмжлэн удирдах болон холбогдох бусад гэрээ;

- 2.6.8 баталгаат үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгон гаргах тохиолдолд түүнийг худалдах гэрээний төсөл;
- 2.6.9 Хорооноос шаардсан бусад мэдээлэл, баримт бичиг.
- 2.7 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагчийг эрсдэл, өгөөжөө тооцож хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг бүрэн тусгасан байна. Үүнд:
- 2.7.1 Баталгаат үнэт цаасны харилцаанд оролцогчдын оноосон нэр, хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн огноо, компанийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, өмнө ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцож байсан туршлагын талаарх мэдээлэл;
- 2.7.2 Үнэт цаас гаргагч ТЗК-ийн товч танилцуулга, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээлэл, хөрөнгийн багцыг шилжүүлэн авсан гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл болон ТЗК татан буугдах тохиолдолд хөрөнгө оруулагчдад бий болох хохирлыг барагдуулах талаар мэдээлэл;
- 2.7.3 ТЗК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлэгч тусгай зөвшөөрөлтэй этгээдийн товч мэдээлэл, хамтран итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж байгаа бол хоорондын байгуулсан гэрээ, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, ТЗК-д үйлчилгээ үзүүлж байсан туршлага, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, үйлчилгээний төлбөр, шимтгэлийн талаар;
- 2.7.4 Хөрөнгийн багцыг бүрдүүлэх зорилгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл худалдагчаас шилжүүлж байгаа хөрөнгө тус бүрийг багцад сонгож оруулсан ерөнхий болон тусгай шалгуур үзүүлэлт, түүнийг тооцох харьцаа үзүүлэлт, шилжүүлэн авч буй хөрөнгийн дүн, хүүгийн түвшин, эргэн төлөгдөх хуваарь, мөнгөн урсгалын тооцоолол, хугацаа, барьцаа хөрөнгийн мэдээлэл, хөрөнгийн багцын чанарын үзүүлэлт, шилжүүлэн авч байгаа хөрөнгө нь эрхийн доголдолгүй байх шаардлагыг хангасан талаар;
- 2.7.5 Хөрөнгийн багцад байгаа хөрөнгүүд эргэн төлөгдөх баталгаа алдагдаж, багцын мөнгөн урсгалд эрсдэл учирсан тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл худалдагчаас багцад бүртгэгдсэн эрсдэлтэй хөрөнгийг дахин худалдан авах, эсхүл өөр төрлийн хөрөнгөөр солихтой холбоотой эрх үүрэг, хариуцлагын талаар болон хөрөнгийн багц дахь хөрөнгөөс хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшигч этгээдээс гадна гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах, шаардах эрх хэрэгжүүлэх эсэх талаарх мэдээлэл;
- 2.7.6 Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хугацаанаасаа өмнө төлөгдөх нөхцөл, энэ тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;
- 2.7.7 Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 болон түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэл;
- 2.7.8 Баталгаат үнэт цаасанд санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол уг зэрэглэлийг тогтоосон байгууллага болон зэрэглэлийн тодорхойлолт, тэмдэглэгээ, тухайн зэрэглэлийг тогтооход суурилсан зах зээлийн эдийн засаг, зах зээлийн нөхцөл бусад хүчин зүйлсийн талаарх мэдээлэл;

- 2.7.9 Баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөх давтамж, хуваарь, хүү тооцох аргачлал, транчтай гаргах тохиолдолд тухайн транчийн ангилал, төлбөр төлөгдөх болон хөрөнгө оруулагчийн эрхээ хэрэгжүүлэх дараалал, үйлчилгээний хөлс, шимтгэлийн талаарх мэдээлэл;
- 2.7.10 Баталгаат үнэт цаасны тухайн хугацаанд төлөгдөх хүүгийн хэмжээнээс илүү гарсан мөнгөн урсгалыг хэрхэн зарцуулах талаарх мэдээлэл;
- 2.7.11 ТЗК-ийн холбогдох дүрэм, журмаар хаалттай хүрээнд санал болгон гаргасан баталгаат үнэт цаасны эзэмшигч үнэт цаасаа эргүүлэн худалдаж авахыг шаардах, байгуулсан гэрээг цуцлах нөхцөлийг тусгасан эсэх мэдээлэл;
- 2.7.12 Баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргасан тохиолдолд энэ талаарх мэдээлэл;
- 2.7.13 Баталгаат үнэт цаасны харилцаанд оролцогчид болон баталгаат үнэт цаастай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийн төрлүүд, эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээний төлөвлөгөө;
- 2.7.14 Баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгон эсхүл хаалттай хүрээнд санал болгон худалдах талаарх мэдээлэл, баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг андеррайтерийн компаниар гүйцэтгүүлсэн бол тухайн андеррайтерийн компанийн мэдээлэл, гэрээгээр хүлээсэн үүрэг;
- 2.7.15 Нийтэд болон хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй баталгаат үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, анхдагч зах зээлд санал болгох, худалдах арга, хэлбэр, зах зээлд санал болгох үнийн арга /тогтоосон үнийн арга, захиалгын бүртгэлийн арга, дуудлага худалдааны арга/;
- 2.7.16 Баталгаат үнэт цаасыг худалдан авагч хөрөнгө оруулагчид ногдох татварын мэдээлэл;
- 2.7.17 Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн үйлчилгээ үзүүлсэн Хороонд бүртгэлтэй хуулийн зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн гаргасан хураангуй дүгнэлт;
- 2.7.18 Хөрөнгөөр баталгаажсан Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн Хороонд бүртгэлтэй аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн гаргасан хураангуй дүгнэлт;
- 2.7.19 баталгаат үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнөх төлөгдөх бусад төлбөр, зардал;
- 2.7.20 Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож буй этгээдүүд хоорондоо нэгдмэл сонирхолтой болон холбоотой этгээд эсэх, бизнесийн холбоо харилцаатай эсэх талаарх мэдээлэл;
- 2.8 Баталгаат үнэт цаасны үндсэн шинжийг тусгасан, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн, үнэн зөв мэдээллийг баталгаат үнэт цаасны танилцуулгад тусгана.
- 2.9 Баталгаат үнэт цаасны танилцуулгын эхний хуудсанд дараах сануулгыг тодоор бичсэн байна:

“Энэхүү танилцуулгад тусгасан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг баталгаат үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг Хороо

хариуцахгүй! Баталгаат үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, баталгаат үнэт цаасны танилцуулга, баталгаат үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

- 2.10 Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц нь нэг болон хэд хэдэн багцад хуваагдаж болох бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах нэг болон хэд хэдэн ангилалтай /транч/ байж болно.
- 2.11 Нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй баталгаат үнэт цаасыг хөтөлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдахгүй.

**ГУРАВ. Тусгай зориулалтын компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ**

- 3.1 ТЗК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багагүй байна.
- 3.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасан Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага гэдэгт дараах этгээдийг тооцно.
  - 3.2.1 Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулдаг, уг үйл ажиллагааг тусгайлан хариуцах нэгжтэй хуулийн этгээд;
  - 3.2.2 Интернет, тоон телевиз, телефон ярианы үйлчилгээ үзүүлдэг, эдгээр үйлчилгээнээс бий болох мөнгөн урсгалыг тусгайлан хариуцах санхүүгийн алба бүхий хуулийн этгээд;
  - 3.2.3 Хорооноос тусгай зөвшөөрөлтэй амьдралын болон ердийн даатгалын компани.
- 3.3 ТЗК-ийг нэгээс дээш үүсгэн байгуулагч хамтран байгуулж байгаа тохиолдолд тус бүрийн эзэмших хувь нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 20 хувиас багагүй байна.
- 3.4 ТЗК-ийн үүсгэн байгуулагч нь Монголбанк болон бусад зохицуулах байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
- 3.5 ТЗК-ийн үүсгэн байгуулагч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байна.
- 3.6 Баталгаат үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ05001-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралтад заасан хавсаргах баримт бичгийг бүрдүүлж Хороонд цаасаар болон цахимаар ирүүлнэ.
- 3.7 ТЗК-ийн дүрэмд зөвхөн Хорооны зөвшөөрлөөр өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөлт оруулсан дүрмийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэх үүрэгтэй.
- 3.8 ТЗК-ийн удирдах дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

- 3.9 ТЗК-ийн үйл ажиллагааг ТУЗ удирдаж, хяналт тавих бөгөөд ТУЗ-ийн гишүүн нь 3 болон түүнээс дээш байх ба нийт гишүүдийн 3/1 нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8-д заасан шаардлага хангасан хараат бус гишүүн байна.
- 3.10 ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүн нь эдийн засаг, эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк, санхүү зэрэг аль нэг чиглэлийн мэргэжил эзэмшсэн, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан хувь хүн байх бөгөөд өөр бусад гурваас дээшгүй ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнээр давхар ажиллаж болно.
- 3.11 ТЗК-ийн ТУЗ нь холбогдох хуульд зааснаас гадна дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:
- 3.11.1 ТЗК-ийн дүрмийн хэрэгжилтийг хангах;
- 3.11.2 ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, ажиллах;
- 3.11.3 ТЗК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.
- 3.11.4 ТЗК-ийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- 3.11.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
- 3.11.6 үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих;
- 3.11.7 хууль тогтоомж, энэхүү журам болон ТЗК-ийн дүрмээр тогтоосон бусад эрх хэмжээ.
- 3.12 ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн хүлээх хариуцлагыг түүнийг сонгосон хуулийн этгээд, хөрөнгө оруулагчид хүлээхгүй бөгөөд ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хариуцлагыг хүлээнэ.
- 3.13 ТЗК-ийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцоноор хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг хууль болон ТЗК-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зохицуулна.
- 3.14 ТЗК-ийн ТУЗ-ийн шийдвэр, холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлээс нэмж, хасч болно.
- 3.15 ТЗК-ийн баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Хороо бүртгэх бөгөөд холбогдох хууль тогтоомжоор нууцад хамаарах мэдээллээс бусад мэдээллийг нийтэд мэдээлнэ.
- 3.16 ТЗК нь хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хадгалах нэгдсэн системтэй, эсхүл гуравдагч этгээдэд гэрээний үндсэн дээр хадгалуулж болох бөгөөд мэдээллийг хадгалагч этгээд мэдээллийн найдвартай, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.17 ТЗК нь үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлана.
- 3.18 ТЗК нь дараах мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор, өөрчлөлт орсон бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим

хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ:

- 3.18.1 төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт;
  - 3.18.2 хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал;
  - 3.18.3 хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ,
  - 3.18.4 төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;
  - 3.18.5 санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан;
  - 3.18.6 хууль тогтоомж, энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл.
- 3.19 ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгасан байна.
- 3.19.1 ТЗК-ийн болон түүний хувьцаа эзэмшигчдийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт;
  - 3.19.2 үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдийн тайлан
  - 3.19.3 томоохон үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагч сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл.
  - 3.19.4 ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл
  - 3.19.5 Энэ журмын 3.22-д заасан тайланг дараа оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргэнэ.

**ДӨРӨВ. Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ**

- 4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчээс хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад ажил, үйлчилгээг эрхэлдэг хуулийн этгээд байна.
- 4.2 Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооны шийдвэрээр тухай бүр зөвшөөрсөн бусад санхүүгийн компани эрхэлж болно.
- 4.3 Үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд түүний доод хэмжээ нь нэг тэрбум төгрөг байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.
- 4.4 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлага хангасан байна.

- 4.4.1. үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь санхүүгийн зах зээл дээр тасралтгүй 1 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
  - 4.4.2. энэ журмын 4.1-д заасан үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, програм, техник хангамжийн нөхцлөөр бүрэн хангагдсан байх;
  - 4.4.3. банкны зүй зохист удирдлагын зарчим болон Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа мөрддөгдүрэм, журмуудад энэ талаар тусгасан байх;
  - 4.4.4. 3-аас доошгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй, тэдгээрийн 3/1 хараат бус гишүүн байх, компанийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнадаг;
  - 4.4.5. Тусгай зөвшөөрөлтэй этгээд бол төрийн эрх бүхий байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуурыг хангаж ажилласан, засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангасан этгээд байх;
- 4.5 Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.
- 4.6 Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас ТЗК болон хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд үйлчилгээ үзүүлэгчийн эсрэг нэхэмжлэл гаргасан этгээд тусгай зориулалтын компаниас хохирлоо барагдуулах нэхэмжлэл гаргах эрхгүй бөгөөд ТЗК-тай сонирхлын зөрчлөөс сэргийлж ажиллана.
- 4.7 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.1-д заасан барьцаалуулсан эд хөрөнгийг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх бүхий этгээд байна.
- 4.8 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий этгээд нь энэхүү журмын 4.4.4-т заасан шаардлага хангасан этгээд байх бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлага хангасан хуулийн этгээдэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.
- 4.9 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.1, 20.2-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл хийх техникийн нөхцлөөр бүрэн хангагдсан байх;
- 4.9.1 хөрөнгийн зохистой удирдлагыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн болон мэдээллийн системийн туршлагатай байх;
  - 4.9.2 гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх.

- 4.10 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх хэмжээг хөрөнгө итгэмжлэн удирдагч болон ТЗК-ийн хооронд байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тогтоох бөгөөд уг гэрээнд дараах зүйлийг тусгана:
- 4.10.1 хөрөнгийн барьцаа, баталгаагаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр шүүхэд нэхэмжлэл гаргах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх харилцаа;
- 4.10.2 үүрэг гүйцэтгэгч хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд хөрөнгө оруулагч болон ТЗК-ийн эрхийг баталгаажуулах арга хэмжээ авах;
- 4.10.3 хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх зохицуулалт.
- 4.11 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл биелүүлэх чадваргүй болсон, дампуурах байдалд хүрсэн бол ТЗК гэрээг цуцалж, шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах эрхтэй.
- 4.12 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ дуусгавар болоход шинээр томилогдсон хөрөнгө итгэмжлэн удирдагчид ТЗК-ийн хөрөнгөд хамаарах бүх баримт бичиг, данс, тооцоо, бэлэн мөнгө, тайлан зэргийг цахим болон бусад хэлбэрээр ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.13 Шинээр хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг өмнөх хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.
- 4.14 Баталгаат үнэт цаас гаргах бүрт хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байна.
- 4.15 ТЗК нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хоёрдогч хөрөнгө итгэмжлэн удирдагчийг ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд анхдагч хөрөнгө итгэмжлэн удирдагч, ТЗК-ийн хооронд байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх бөгөөд хоёрдогч хөрөнгө итгэмжлэн удирдагч нь анхны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хяналт дор ажиллана.
- 4.16 ТЗК нь хөрөнгө итгэмжлэн удирдагч солигдсон тухай бүр ажлын 3 хоногт багтаан Хороо болон хөрөнгө оруулагчдад мэдэгдэх үүрэгтэй.
- 4.17 Хөрөнгө итгэмжлэн удирдах удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягт СЗХ05002-ийн дагуу гаргасан өргөдөл, 4 дүгээр хавсралтад заасан хавсаргах баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлж Хороонд цаасаар болон цахимаар ирүүлнэ.
- 4.18 Хороо нь хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.
- 4.19 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

- 4.20 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр олгохоос татгалзана. Үүнд:
- 4.20.1 хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;
  - 4.20.2 хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь тохиромжтой этгээдийн шаардлага хангаагүй;
  - 4.20.3 энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.
- 4.21 Ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй, нэмж тодруулах шаардлагатай бол Хороо албан бичгээр мэдэгдэж, хууль журмын шаардлагын дагуу нэмж бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.
- 4.22 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.23 Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн хүсэлт гаргагч хуулийн этгээдээс хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.
- 4.24 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, гүйцэтгэх удирдлагыг шинээр томилох, оноосон нэр өөрчлөх, салбар төлөөлөгчийн газар байгуулах тохиолдолд Хорооны даргын тушаалаар зөвшөөрөл олгоно.
- 4.25 Энэхүү журмын 4.23-д заасан зөвшөөрлийг авахдаа Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасан баримт бичгийг Хороонд бүрдүүлж ирүүлнэ.

**ТАВ. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгон худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх**

- 5.1 Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Хороо бүртгэж, олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, хөрөнгө татан төвлөрүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.
- 5.2 ТЗК нь баталгаат үнэт цаасыг андеррайтерийн компани эсхүл арилжаа эрхлэх байгууллага, биржийн бус зах зээлээр дамжуулан анхдагч зах зээлд зөвхөн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулагчдад санал болгон худалдана.
- 5.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ нь үнэт цаасны танилцуулгад заасан хэмжээнээс доошгүй байна.
- 5.4 Баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд хөрөнгө оруулагчдад санал болгон худалдах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэгч тухайлсан болон төвлөрсөн бүртгэл хөтлөгч этгээдийн тусгаарласан дансанд байршуулна.

- 5.5 Хорооноос баталгаат үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эрхлэх зөвшөөрөл олгох хүртэлх хугацаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээд энэхүү журмын 5.4-д заасан мөнгөн хөрөнгийг зарцуулах эрхгүй байна.
- 5.6 Баталгаат үнэт цаас гаргагч ТЗК нь үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг нэг сарын хугацаанд зохион байгуулж, үнэт цаасны танилцуулгад тусгасан хэмжээнд хөрөнгийг татан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна.
- 5.7 ТЗК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нь баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, эсхүл биржийн бус зах зээлээр дамжуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага, мэргэжлийн холбоо нь баталгаат үнэт цаасыг өөрийн бүртгэлд бүртгэх, анхдагч зах зээлд санал болгон худалдах, байршуулах, хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.
- 5.8 ТЗК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нь баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаа эрхлэх болон биржийн бус зах зээлд санал болгон худалдах, байршуулах, захиалгын бүртгэлийг хийх ажиллагааг андеррайтерийн компанитай хамтран зохион байгуулна.
- 5.9 ТЗК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч компани нь баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах болон худалдах хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.
- 5.10 ТЗК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нь баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдаж, үнэт цаасны танилцуулгад заасан мөнгөн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл хүснэ.
- 5.11 Хорооноос энэхүү журмын 5.10-д заасан тайланг хянаад үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийг татан төвлөрүүлсэн гэж үзвэл хоёрдогч зах зээлийг эхлүүлэх зөвшөөрлийг ажлын 3 хоногт багтаан өгнө.

**Зургаа. Барьцаат үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасны танилцуулгын агуулга,  
тусгай зөвшөөрлийн шаардлага**

- 6.1 Барьцаат үнэт цаас нь орон сууцны зээл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, тодорхой нөхцөлтэй үнэт цаас байна.
- 6.2 Барьцаат үнэт цаасыг зөвхөн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 26.1-д заасан этгээд тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр барьцаат үнэт цаасыг гаргаж болно.
- 6.3 Орон сууцны санхүүжилтийн компани нь барьцаат үнэт цаас гаргахаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан этгээд, банкны хувьд Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд байна.

- 6.4 Барьцаат үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг барьцаат үнэт цаас гаргах бичиг баримтыг, өргөдөлтэй хамт Хороонд ирүүлнэ.
- 6.5 Орон сууцны санхүүжилтийн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2 тэрбум төгрөгөөс доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.
- 6.6 Барьцаат үнэт цаас гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна.
- 6.6.1. барьцаат зээлийн үйл ажиллагааны болон эрсдэлийн удирдлагын нэгжтэй байх;
  - 6.6.2. Банкны тухай хууль болон Хорооноос баталсан журмаар тогтоосон шаардлагыг 1 жилийн хугацаанд хангаж ажилласан байх;
  - 6.6.3. барьцаат үнэт цаас гаргах, удирдах байгууллагын бүтэц хүний нөөцийн болон програм хангамжтай байх;
  - 6.6.4. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийгсүүлийн 4 улирал дараалан хангасан байх;
  - 6.6.5. барьцаат үнэт цаас гаргагчийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;
  - 6.6.6. ТУЗ нь 3/1-ээс доошгүй хараат бус гишүүнтэй байх;
- 6.7 Барьцаат үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй эсхүл хаалттай хүрээнд гаргаж болно.
- 6.8 Барьцаат үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад андеррайтерийн компаниар дамжуулан арилжаа эрхлэх болон биржийн бус зах зээлээр дамжуулан гаргаж болно.
- 6.9 Барьцаат үнэт цаасыг Хороо бүртгэнээс хойш 6 сарын хугацаанд олон нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох ажиллагааг гүйцэтгэнэ.
- 6.10 Барьцаат үнэт цаас гаргах хүсэлттэй хамт дараах бичиг баримтыг Хороонд бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ:
- 6.10.1 барьцаат үнэт цаасны танилцуулга;
  - 6.10.2 Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан талаарх мэдээдэл;
  - 6.10.3 хувьцаа эзэмшигчдийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтойгоор эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл болон уг этгээдийн хувьцааг нь эзэмшдэг бусад хуулийн этгээдийн нэр, эзэмшдэг хувьцааны тоо, ширхэг;
  - 6.10.4 компанийн дүрмийн хуулбар;
  - 6.10.5 барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, , туршлага, барьцаат үнэт цаасыг хянах гэрээний төсөл;
  - 6.10.6 барьцаат үнэт цаасны барьцаа, баталгаатай холбоотой үнэт цаас гаргагчийн үзүүлэх үйлчилгээний журмын төсөл;
  - 6.10.7 хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор гуравдагч этгээдийн гаргасан баталгаа болон баталгаа гаргагчтай холбоотой зохих санхүүгийн мэдээлэл;
  - 6.10.8 барьцаат үнэт цаас гаргагчийн сүүлийн 1 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

- 6.10.9 гурван жилийн бизнес төлөвлөгөө;
- 6.10.10 нэмж барьцаат үнэт цаас гаргаж байгаа бол өмнөх гаргасан үнэт цаасны үлдэгдэл, түүний эргэн төлөлт болон зээлийн хөрөнгийн талаарх мэдээлэл;
- 6.10.11 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж болон Хорооноос шаардсан бусад мэдээлэл.
- 6.11 Энэ журмын 2.6-д заасан шаардлага барьцаат үнэт цаасанд хамаарна.
- 6.12 Барьцаат үнэт цаас гаргах хүсэлт, танилцуулгад барьцаат үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 6.13 Хороонд бүртгүүлэх барьцаат үнэт цаасны танилцуулгад дараах мэдээллийг тусгана:
  - 6.13.1 барьцаат үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл;
  - 6.13.2 барьцаат үнэт цаасны нэрлэсэн үнэ, тоо ширхэг болон барьцаа хөрөнгийн жагсаалт;
  - 6.13.3 барьцаат үнэт цаасны тоо, эргэн төлөлт, хүү, хүүг тооцох аргачлал, төлбөрийн хуваарь, үнэт цаас гаргагч барьцаат үнэт цаасыг эргүүлэн худалдан авах нөхцөл, хөрөнгө оруулагчийн эрх, тэдгээрийн бүртгэл, захиалга өгөх худалдахтай холбоотой мэдээлэл;
  - 6.13.4 орон сууцны зээл, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл;
  - 6.13.5 барьцаат үнэт цаас гаргахын өмнөх үнэт цаас гаргагчийн орон сууцны зээлийн нийт багц дахь зээлийн чанар;
  - 6.13.6 орон сууцны зээлийн хүү, хувьсах хүүгийн нөхцөл;
  - 6.13.7 орон сууцны зээл эрсдэлд орсон тохиолдолд түүнийг солих нөхцөл;
  - 6.13.8 одоогийн үнэ, барьцааны бүртгэлд бүртгэгдсэн байдал;
  - 6.13.9 барьцаат үнэт цаасны барьцааны жигнэсэн дундаж өгөөж;
  - 6.13.10 орон сууцны зээлийн үлдэгдэл, түүний эргэн төлөлтийн байдал;
  - 6.13.11 барьцаат үнэт цаас гаргахтай холбоотой барьцааны бүртгэлийг тооцоолсон баланс, орлогын мэдүүлэг;
  - 6.13.12 үнэт цаасны эрсдлийн шинжилгээ, 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлийн төсөөлөл;
  - 6.13.13 Барьцаат үнэт цаасны санал болгох үнийг тогтоосон арга, үнэлгээний компани үнэлгээ гаргасан бол үнэлгээний тайлан.
- 6.14 Барьцаат үнэт цаас гаргагч нь барьцааны хөрөнгийн барьцааг бүртгүүлж, бүртгэлийг хадгалах бөгөөд бүртгэлийг цахим хэлбэрээр хадгална.
- 6.15 Барьцаат үнэт цаас гаргагч нь барьцаатай холбоотой дараах мэдээллийг барьцааны бүртгэлд тусгана:
  - 6.15.1 үүрэг гүйцэтгэгчийн нэр, хаяг, регистрийн дугаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, үндсэн зээлийн хэмжээ, хүү, хүүг тооцох арга, барьцааны зүйлийн хаяг, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар, өмчлөгч болон хамтран өмчлөгчийн талаарх мэдээлэл;
  - 6.15.2 барьцаат үнэт цаасны бүртгэлийн дугаар, түүний нэрлэсэн үнэ, эргэн төлөлтийн хувиар, хүү, хүүг тооцох арга;
  - 6.15.3 зээлийн үлдэгдэл, үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн талаарх мэдээлэл;

6.16 Энэ журмын 6.15-д заасан мэдээлэлтэй зөвхөн Хороо болон барьцааны бүртгэлийг хянагч танилцах эрхтэй.

**Долоо. Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах шаардлага**

7.1 Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хөтлөлтөд хяналт тавих, хөрөнгийн багцын хэвийн байдлыг хангах, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэг бүхий хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийг хуульд заасан журмын дагуу барьцаат үнэт цаас гаргагч томилох бөгөөд түүнтэй гэрээ байгуулна.

7.2 Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

7.3 Хорооноос хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон журам, үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулна.

7.4 Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь дараах шаардлагыг хангасан хуулийн этгээд байна:

7.4.1 гүйцэтгэх захирал, мэргэжилтэн нь эдийн засгийн болон эрх зүйн чиглэлээр 2-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

7.4.2 эдийн засаг, эрх зүй, банк санхүү, хөрөнгийн зах зээлийн талаарх мэргэшсэн боловсон хүчинтэй байх ба үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан 1-ээс доошгүй мэргэжилтэнтэй;

7.4.3 хуулийн этгээдийн удирдлага нь үнэт цаасны зах зээлийн тухай болон банкны тухай хууль тогтоомжийг зөрчиж хариуцлага хүлээж байгаагүй, эдийн засгийн болон аж ахуйн эсрэг гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгэгдэж байгаагүй этгээд байх;

7.4.4 үнэт цаас гаргагчтай аливаа хэлбэрийн холбоогүй, нэгдмэл сонирхолгүй, сонирхлын сонирхлын зөрчилгүй байх;

7.5 Энэ журмын 7.4-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээд хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон түүнтэй холбогдох дараах бичиг баримтыг Хороонд ирүүлнэ:

7.5.1 тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

7.5.2 улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.5.3 өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны танилцуулга, бизнесийн төлөвлөгөө;

7.5.4 компанийн дүрэм, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүдийн талаарх мэдээлэл, тэдгээрийн тохиромжтой этгээдийн шаардлага хангасныг тодорхойлох баримт бичиг;

7.5.5 өмнө нь тухайн төрлийн үйл ажиллагаа эрхлэж байсан бол түүнийг нотолсон бичиг баримт, сүүлийн 1 жил хийж гүйцэтгэсэн ажлын тайлан;

7.5.6 хууль болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад материал.

- 7.7 Энэ журмын 7.6-д заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш Хороо 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Хэрэв Хороо нь хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэл бүхий хариуг бичгээр мэдэгдэнэ.
- 7.8 Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг зрөчсөн бол Хорооноос түүний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 7.9 Үнэт цаас гаргагч нь Хорооны зөвшөөрөлтэйгөөр хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийг солих эрхтэй бөгөөд мөн Хороо нь түүнийг солих шаардлагыг үнэт цаас гаргагчид тавих эрхтэй.
- 7.10 Барьцаат үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон үед Хорооноос албан бичгээр хөрөнгийг шилжүүлэх, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах сан байгуулах, эсхүл шинээр томилогдсон хөрөнгийн багцыг хянагчид барьцааны бүртгэлийг танилцуулж болно.
- 7.11 Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч нь төлөвлөгөөт шалгалтыг сард нэгээс доошгүй удаа хийх бөгөөд шалгалт дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан шалгалтын тайланг үнэт цаас гаргагч болон Хороонд тус бүр нэг хувийг хүргүүлэх ба энэ талаар нийтэд мэдээлнэ.
- 7.12 Барьцаат үнэт цаасны барьцаатай холбоотой эх хувь бүхий бичиг баримтуудыг үнэт цаас гаргагч нь баталгаатай, аюулгүй орчинд хадгалах үүрэгтэй бөгөөд энэ бичиг баримтад хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч хэдийд ч шалгалт хийх эрхтэй.

### **Найм. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад тавих шаардлага, нэмэлт хөрөнгийн үнийг тооцох**

- 8.1 Нэмэлт хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 30.1-д заасан хөрөнгөөс бүрдэнэ.
- 8.2 Энэ журмын 8.1-д заасан нэмэлт хөрөнгийг үнэлэхдээ дараах аргачлалаар үнэлнэ:
- 8.2.1 бэлэн мөнгийг нэрлэсэн өртгөөр;
  - 8.2.2 Монгол улсын Засгийн газар болон Монголбанкны үнэт цаасыг түүний нэрлэсэн үнээр;
  - 8.2.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 30.1.3-д заасан хөрөнгийг одоогийн зах зээлийн үнээр тооцно.
- 8.3 Багцад нэмэгдсэн хөрөнгө нь үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.
- 8.4 Хөрөнгийг нэмэгдүүлэх нь барьцаат үнэт цаасны эргэн төлөх хугацаанд нөлөөлөхгүй.
- 8.5 Багцын барьцаанд орсон хөрөнгийг үнэт цаас гаргагчийн тусдаа дансанд хадгалах бөгөөд харин үнэт цаасыг үнэт цаасны хадгаламжийн байгууллага дахь үнэт цаас гаргагчийн дансанд хадгална.
- 8.6 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 30.2-т заасны дагуу харьцааг тооцохдоо барьцааны бодит үнэд суурилан нэмэлт хөрөнгө, үндсэн хөрөнгө хоёрын харьцааг баримтлана.

8.7 Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаас гадна тухайн хөрөнгө нь дараах шаардлагыг хангасан байна.

8.7.1 орон сууцны зээлийн жигнэсэн дундаж үлдэгдэл барьцаат үнэт цаасны эргэн төлөлтийн үлдэгдэлтэй тэнцүү буюу их байх бөгөөд үүнийг хангаагүй тохиолдолд нэмэлт хөрөнгөөр хөрөнгийн багцыг нэн даруй нэмэгдүүлнэ;

8.7.2 олон өрх оршин суух эсвэл дан ганц гэр бүл оршин суухад зориулан баригдсан, хүн амьдран суух зориулалттай үл хөдлөх хөрөнгө;

8.7.3 үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн барьцааны зүйлээс тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах;

8.7.4 барьцааны үл хөдлөх хөрөнгө нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр баригдсан хөрөнгө байх бөгөөд үүнд гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын үл хөдлөх хөрөнгө хамаарахгүй;

8.7.5 тухайн хөрөнгө нь эд хөрөнгийн даатгалд даатгагдсан байх ба хэрэв хөрөнгөд эрсдэл гарвал даатгалын нөхөн төлбөрөөр хөрөнгө оруулагчдад төлөх төлбөрийг барагдуулна;

8.7.6 ~~7.7.6. орон сууцны үл хөдлөх хөрөнгө нь олон айл амьдрах орон сууцны зориулалттай бол Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд заасан дундын удирдлага (СӨХ) тай байна;~~ /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 255 дугаар тогтоолоор хассан/

8.7.7 барьцаанд бүртгэгдэхдээ тухайн хөрөнгө нь ямар нэгэн өр төлбөргүй, бусдын өмнө шаардах эрх үүсгээгүй, эрхийн доголдолгүй байх бөгөөд хэрэв эрсдэл гарвал тухайн хариуцлагыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагч хамтран хариуцна;

8.8 Барьцаат үнэт цаасны барьцааны хөрөнгийн зээлийн хэмжээнд аливаа хэлбэрийн хязгаарлалт байхгүй.

8.9 Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тодорхойлсноор хөрөнгө оруулагчдад хуваарилахаас өмнө дараах төлбөрүүдийг төлнө:

8.9.1 энгийн бүртгэл, зарлал мэдэгдэл, үнэт цаас гаргах зардал, төлбөр;

8.9.2 үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудит, хөрөнгийн үнэлгээчин, хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх төлбөр;

8.9.3 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал;

8.9.4 баталгаа гаргагчтай бол түүнд төлсөн төлбөр, хураамж;

8.9.5 зээлийн зэрэглэл тогтоох этгээд болон үнэт цаасны зуучлагчид төлсөн төлбөр;

8.9.6 хуулиар төлөх үүрэг хүлээсэн албан татвар, төлбөр, хураамж;

8.9.7 Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс;

8.9.8 Хууль болон гэрээгээр тодорхойлсон бусад төлөгдөх зардлууд.

8.10 Энэ журмын 8.9-д заасан төлбөр нь баримтаар нотлогдож байх бөгөөд хууль зөрчиж, хөрөнгө оруулагчийн эрх ашигт хохиролтой гэрээ хэлцэл байгуулж, эсхүл зах зээлийн ханшаас өндөр үнэ тогтоож төлбөр төлөхийг хориглоно.

8.11 Энэ зүйлд заасан мэдээллийг хөрөнгө оруулагч нарт тогтмол мэдээлж байх бөгөөд хэрэв өөрчлөлт орсон бол тухбүр ажлын 3 хоногийн дотор хөрөнгө оруулагчдад мэдээлнэ.

**Ес. Аудитын компанид тавигдах шаардлага,  
түүний хяналт хийх хэлбэр**

- 9.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд Хороонд бүртгэлтэй хөндлөнгийн аудитын компаниар жилд нэгээс доошгүй удаа аудит хийлгэж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн нөхөрлөлөөр дүгнэлт гаргуулна.
- 9.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд аудит хийх этгээд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1-т заасны дагуу Хороонд бүртгэлтэй аудитын компани байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.
- 9.2.1 санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, аудитын үйл ажиллагааг тасралтгүй 1 болон түүнээс дээш жил эрхэлсэн;
- 9.2.2 Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан, Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шаардлагыг хангасан байх;
- 9.2.3 аудиторуд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй;
- 9.2.4 Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.
- 9.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь дараах хүрээг хамарсан байна:
- 9.3.1 тайлант хугацааны хөрөнгийн орлогын ашиглалтын байдал;
- 9.3.2 үндсэн зээлийн эргэн төлөлтийн хэмжээ, зээлийн үлдэгдэл;
- 9.3.3 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эргэн төлөлтийн байдал, алдагдал;
- 9.3.4 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үлдэгдэл, үндсэн зээлийн баланс;
- 9.3.5 төлбөрийн чадваргүй байдал, зөрчил, алдагдал;
- 9.3.6 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан дансны тайлан тооцоо, одоогийн тайлан тэнцэл, нөөц, тэдгээрийн урсгалд тавих хяналт;
- 9.3.7 Аудитын тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан бусад хүрээг хамруулна.
- 9.4 Хөндлөнгийн аудитын компани жилийн тайланд үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн орлого хэрхэн ашиглагдсан талаарх болон энэ журмын 9.3-т заасан асуудлуудыг тусгасан байна.
- 9.5 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1-т заасны дагуу үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд аудит хийх эрх авах этгээд нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн Хороонд ирүүлнэ:
- 9.5.1 эрх авахыг хүссэн өргөдөл;
- 9.5.2 компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар, холбогдох тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- 9.5.3 орон тооны аудиторын анкет, тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл, эрхийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, тэдгээрийн нийгмийн

даатгалын шимтгэлийг компани төлдөг тухай холбогдох нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

9.5.4 аудиторуд нь мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх талаарх Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институтийн лавлагаа;

9.5.5 аудитын сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга, нотлох баримтын хамт.

9.6 Энэ журмын 8.5-д заасан эрх олгохыг хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш Хороо 30 хоногийн дотор албан бичгээр шийдвэрлэнэ. Хэрэв Хороо нь аудитын эрх олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэл бүхий хариуг бичгээр мэдэгдэнэ.

9.7 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд анх удаа болон нэмж гаргах ажиллагаанд хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн нөхөрлөл нь Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу Хороонд бүртгүүлсэн этгээд байна.

9.8 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн нөхөрлөл нь дүгнэлтийг Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын агуулгаас гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч, багцалсан хөрөнгийн чанар, багцалсан хөрөнгийн гэрээний стандарт нөхцөл, багцалсан хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах хууль зүйн боломж, нөхцөл, эдийн болон эдийн бус хөрөнгийг багцлах хуулийн зүйн боломж, нөхцлийн талаар дүгнэлтийг гаргана.

#### **Арав. Үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлтийг Хороо хянан шийдвэрлэх**

10.1 Хороо хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлт болох өргөдөл, үнэт цаасны танилцуулга зэрэг бичиг баримтыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж болон энэхүү журамд заасан шаардлагыг хангасан холбогдох бичиг баримтыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногт хянаж шийдвэрлэх бөгөөд хугацааг холбогдох бичиг баримт шаардлагад нийцэж, бүрэн бүрдсэн өдрөөс эхлэн тооцно.

10.2 Хороонд бүртгэсэн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгыг дараах байдлаар баталгаажуулна:

10.2.1 Товч танилцуулгад Хорооны шийдвэртэй холбоотой мэдээллийг бүрэн тусгана;

10.2.2 Тухайн үнэт цаасны 2 хувь танилцуулга, түүнд хавсаргасан бүх бичиг баримтын хуудас бүрийн зүүн дээд өнцөгт “Санхүүгийн зохицуулах хороо бүртгэв” гэсэн тэмдэг дарж, огноог тэмдэглэж баталгаажуулна.

10.3 ТЗК-ийн баталгаат үнэт цаасыг бүртгэхээс өмнөх 1 жилийн дотор түүний үүсгэн байгуулагчид Монголбанк болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагаас захиргааны хариуцлага ногдуулж байсан бол энэ нь Хороо ТЗК-д тусгай зөвшөөрөл олгох, гаргаж буй үнэт цаасыг бүртгэхээс татгалзах үндэслэл болох бөгөөд үүнийг Хороо шийдвэрлэнэ.

10.4 Хороо болон бусад төрийн зохицуулах байгууллагаас үүсгэн байгуулагчдын удирдлагад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл Хороо тэднийг тохиромжгүй этгээд гэж үзсэн бол үнэт цаасыг бүртгэхээс татгалзаж болно.

**Арван нэг. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой Хорооны бүрэн эрх**

- 11.1 Хороо нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр салбарын эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, бодлого тодорхойлох чиглэлээр оролцогчдоос мэдээлэл гаргуулан авах эрхтэй.
- 11.2 Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгон нээлттэй, мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгон хаалттай хүрээнд санал болгон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган санал болгон гаргах үнэт цаасны танилцуулгын агуулгыг тогтоох, тогтоосон хугацааны болон тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулгыг тогтооно.
- 11.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн бус зах зээлээр дамжуулан мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох нөхцөлд мэдээллийн ил тод байдлыг биржийн бус зах зээлийн арилжааг зохион байгуулагч хариуцаж, гүйцэтгэлийн тайланг Хороонд улирал тутам ирүүлнэ.
- 11.4 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоогч байгууллага оролцсон нөхцөлд Хорооноос тухай үйлчилгээ үзүүлэгч этгээд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллана.

---oOo---